



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН  
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН 2021 ОНЫ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН 2021 ОНЫ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



УЛААНБААТАР ХОТ  
2022 ОНЫ

**ХЯНАСАН:**

Д. Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

**ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН :**

Ч.Дархансоёмбо

ЧД-ын Статистикийн мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС  
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот

Утас : 70130767, 70113013

70110767

Цахим хуудас : [www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

[www.chingeltei.gov.mn](http://www.chingeltei.gov.mn)

И-мэйл: chingeltei@nso.mn



## 1. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Үндэсний Статистикийн хороо нь олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний түүвэр судалгаа” (АХС) -г улирлаар явуулж байна.

Энэхүү **судалгааны зорилго** нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тухайн хугацаа буюу сүүлийн 7 хоногоор тодорхойлж, дүн шинжилгээ хийх тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Судалгааг 2006-2018 онуудад Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 1982 оны 13-р бага хурлын тогтоолын дагуу боловсруулагдсан Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн аргачлал, арга зүйн дагуу явуулж байсан.

Харин **2019 оноос эхлэн шинэ аргачлал, ойлголт тодорхойлолтын дагуу явуулж байна.** Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 2013 онд болсон 19-р бага хурлаар 1982 оны 13-р бага хурлаас баталсан аргачлал нь хөдөлмөрийн зах зээлийн бодит дүр зургийг төдийлөн илэрхийлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байгааг онцолж, аргачлалыг шинэчлэх шийдвэр гаргасан юм. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин дангаараа ажиллах хүчний дутуу ашиглалтыг бүрэн харуулж чадахгүй байгаа тул ихэнх орнуудын ажиллах хүч, ажилгүйдлийн түвшнийг тооцоход ашиглаж байгаа эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг шинэчлэхийг чухалчилсан.

Маш хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харуулахын тулд бид олон улсын шинэ аргачлалыг өөрийн орны онцлогт тусган нэвтрүүлж, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал”-ыг батлан 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг шинэчилснээр хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг шинээр бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангах юм.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний дутуу ашиглалт”-ын талаарх тогтоолын дагуу хөдөлмөрийн статистикийн ойлголт, аргачлалд гарсан томоохон өөрчлөлтийг дурдвал:

- ✓ **Цалин хөлс, орлого олох зорилгоор** ажиллаж буй ажиллагчдын тодорхойлолт, үзүүлэлтийг сайжруулсан (Ингэснээр бусад төрлийн ажил, тухайлбал, өөрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг ажиллагчдаас ялгах боломжтой болж байгаа юм).
- ✓ **Хөдөлмөрийн насны хүн амыг** 15 ба түүнээс дээш насаар тогтоосон.
- ✓ Ажиллагчдын **үндсэн ажлын** шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.

- ✓ **Ажилгүй хүний** шалгуур шинэчлэгдэн, цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа гэсэн 3 шалгуурыг хангасан хүнийг хэлэх болсон. Өмнө нь “сүүлийн 2 шалгуурын аль нэгийг нь хангах” гэж авч үзэж байсан. Мөн насны дээд хязгааргүй болсон.
- ✓ Ажиллах хүчний дутуу ашиглалтыг хэмжих уламжлалт үзүүлэлт буюу ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшнээс илүү өргөн хүрээний **хөдөлмөрийн дутуу ашиглалт, түүний түвшнүүд** бүхий шинэ үзүүлэлтүүдийг бий болгосон.

- **Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм. Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;
- Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Зураг 1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, 2021



Ажиллах хүчний судалгаанд баг, хороодоос түүврээр сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж, үр дүнг гаргадаг.

Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцоход 2021 онд улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1225369 байгаагийн 516903 нь Улаанбаатар хотод, 52901 нь Чингэлтэй дүүрэгт байна.


Хүснэгт 1. Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Нийт хүн ам	159 051	157 258	148 977	151 203	150 548
15 ба түүнээс дээш насны нийт хүн ам	109 212	109 547	103 262	99 955	102 470
Ажиллах хүч	52 259	55 510	58 260	54 441	52 901
Үүнээс: Ажиллагчид	43 600	47 978	51 702	51 172	47 962
Ажилгүй иргэд	8 659	7 532	6 558	1 383	4 939
Ажиллах хүчнээс гадуурхи хүн ам	50 665	47 765	45 002	45 514	50 389
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	50.8	53.7	56.3	54.5	51.2
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	42.4	46.5	50.1	54.2	47.7
Ажилгүйдлийн түвшин, %	16.6	13.6	11.3	6.0	9.3

Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 51.2 хувьтай байна.

Ажиллах хүчний судалгааны тооцоогоор эдийн засгийн идэвхтэй хүн ам 52901 байгаагаас 90.7 хувь нь ажиллагчид 9.3 хувь нь ажилгүй иргэд байна.

Зураг 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт




Хүснэгт 2. Дүүргийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Нийт хүн ам	82 653	80 779	77 420	77 633	77198
15 ба түүнээс дээш насны нийт хүн ам	59 551	57 593	55 940	55 824	57717
Ажиллах хүч	23 843	25 496	26 753	27 409	24048
Үүнээс: Ажиллагчид	21 117	22 859	25 081	26 026	25819
Ажилгүй иргэд	2 726	2 637	1 672	1 383	1771
Ажиллах хүчнээс гадуурхи хүн ам	32 446	30 200	29 187	28 415	31898
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	41.6	45.8	47.8	49.1	44.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	36.9	41.0	44.8	46.6	41.7
Ажилгүйдлийн түвшин, %	11.4	10.3	6.2	5.0	6.9

Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 44.7 хувьтай байна. Ажиллах хүчний судалгааны тооцоогоор эдийн засгийн идэвтэй хүн ам 24048 байгаагаас 93.1 хувь нь ажиллагчид 6.9 хувь нь ажилгүй иргэд байна.

Зураг 3. Дүүргийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт



Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцоход 2021 онд улсын хэмжээнд 1225369 ажиллагчид байгаагийн 516903 нь Улаанбаатар хотод, 52901 нь Чингэлтэй дүүрэгт байна.

Хүснэгт 3. Ажиллагчдын тоо, дүүргээр

Засаг захиргаа	2017	2018	2019	2020	2021
Улсын дүн	1 238 333	1 253 023	1 146160	1162912	1 125 591
Нийслэлийн дүн	512 189	513 053	470 998	517 427	475 806
Багануур, Багахангай, Найлах	23 080	21 963	24 620	23 166	14954

Баянгол	78 942	78 421	65 633	83 919	68150
Баянзүрх	148 491	140 347	116 883	140 609	127647
Сонгинохайрхан	110 450	111 318	105 850	111 025	109292
Сүхбаатар	48 255	51 066	45 602	51 208	44489
Хан-Уул	60 488	60 556	60 708	56 328	63312
Чингэлтэй	43 600	47 978	51 702	51 172	47962

Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагсдын тоо 2021 онд 47962 болж өмнөх оноос .... хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Ажилгүй иргэдийн тоо, дүүргээр

<i>Засаг захиргаа</i>	2017	2018	2019	2020	2021
<i>Улсын дүн</i>	119 092	105 614	127 736	87 696	997 78
Нийслэлийн дүн	41 388	42 294	58 469	34 714	41 097
Багануур, Багахангай, Найлах	1 522	2 645	2 331	1971	313
Баянгол	4 919	4 201	4 016	6 037	8 173
Баянзүрх	11 246	8 091	16 761	6529	11 650
Сонгинохайрхан	4 309	12 291	16 241	10 460	6 711
Сүхбаатар	3 671	3 166	5 327	1 536	3 840
Хан-Уул	7 062	4 368	7 235	4 912	5 471
Чингэлтэй	8 659	7 532	6 558	3 269	4 939

Зурга 4 . Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хүйсээр

